



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн зарим гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хороолол дотор байгуулах "Ойн төгөл"-үүдэд тарих гоёл, чимэглэлийн мод, сөөг нийлүүлэх нийлүүлэгчид болон нийлүүлэх мод, сөөгний нэр төрөл, тоо хэмжээ, зарцуулах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гоёл чимэглэлийн мод, сөөгийг нийлүүлэх нийлүүлэгчидтэй гэрээ байгуулах, мод, сөөгийг хүлээн авах, мод, сөөгийг хуваарилан тариулах ажлыг зохион байгуулах, тарилтын ажилд мэргэжлийн хяналт тавьж, ажлын явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Гоёл чимэглэлийн мод, сөөг худалдан авах ажилд шаардагдах нийт 421.900.000 /Дөрвөн зуун хорин нэгэн сая есөн зуун мянган/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/ -д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2019 оны *дунд* сарын *15* өдрийн  
*А.Ю.Сүр* тушаалын хавсралт

ГУДАМЖ, ЦЭЦЭРЛЭГТ БОЛОН “ОЙН ТӨГӨЛ”-ҮҮДЭД  
 ТАРИХ МОД, СӨӨГ НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД,  
 НИЙЛҮҮЛЭХ МОД, СӨӨГНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ,  
 ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

№	Мод сөөг тарих байршил, ажлын нэр	Мод, сөөгний нэр, төрөл, өндрийн хэмжээ	Тоо хэмжээ /ш.бут/	Мод, сөөг нийлүүлэх байгууллагын нэр	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1.	Наадамчдын автозам дагууд /замын урд талаар/ тарих ургамлан хашлаганы сөөг нийлүүлэх ажил	Хайлаас /1,0-1,5м өндөртэй/	10000ш 10000ш 30000ш  15000ш	Да ха шим ХХК Зуун хас ХХК Шаамар питомник ХХК Ариун шимт байгаль ХХК	1000  800  900  1000	10.000.000 8.000.000 27.000.000  15.000.000
		Хайлаас /0,7-0,9м өндөртэй/	20000ш	Ойн баясах ХХК	600	12.000.000
2.	Наадамчдын автозам дагууд /замын урд талаар/ тарих гоёлын бут сөөг нийлүүлэх ажил	1.Голт бор /0,8-1,2м өндөртэй модлог/	2320ш	Бүрэн хаан санжаа ХХК	15.000	34.800.000
		2.Голт бор /0,6-0,8м сөөгөн/	2000ш	Ойн баясах ХХК	12.000	24.000.000
3.	Бага тойруугийн гудамж /5-р сургуулиас УБИСхүртэл/-нд гоёлын мод, бут сөөг нийлүүлж, тарих ажил	1.Хүрэн навчит монос /1,8-2,0 м өндөр/	320 бут	Байгалиа дээдлэе ХХК	110.000	35.200.000
		2.Шар навчит хайлаас /1,8-2,0 м өндөр/	450 бут	Байгалиа дээдлэе ХХК	110.000	49.500.000
		3.Хүрэн навчит хайтан /1,8-2,3 м өндөр/	350 бут	Байгалиа дээдлэе ХХК	110.000	38.500.000

		4. Тэхийн шээг, Далан хальс /0,7-0,8 м өндөр/	1200 бут	Ногоон төгөл ХХК	25.000	30.000.000
4.	Их тойруугийн гудамж /Эвтэй 4 амьтны хөшөөнөөс зүүн 4 замын уулзвар хүртэл/	1.Далан хальс/0,7-0,8 м өндөр/	200 бут	Төгөл ХХК	48000	9.600.000
5.	Орон сууцны хороололд байгуулах "Ойн төгөл"-үүдэд таригдах мод, сөөг нийлүүлэх ажил	1.Гацуур /1,8-2,0м өндөр/	350ш	Халх голын хишиг ХХК	140.000	49.000.000
		2.Агч мод /2,0-2,5м өндөр/	2500ш	Мандан баясах ХХК	8000	20.000.000
		3.Улиас 2,0-2,5м өндөр /	1000ш	Төгөл шинэст ХХК	5000	5.000.000
			400ш	Да ха шим ХХК	5000	2.000.000
			500ш	Устын улиасХХК	5000	2.500.000
			400ш	Тансаг ландшафт ХХК	5000	2.000.000
6.	Моносын уулзвараас хуучин 22-ын товчооны салдаг уулзвар хүртэл автозамын 2 тал болон голын тусгаарлах зурваст тарих мод, сөөг нийлүүлэх ажил	1.Улиас /2,0-3,0м өндөр/	5000 ш	Мандан баясах ХХК	5000	25.000.000
		2.Хайлаас /0,7-0,9м өндөртэй/	38000ш	Ойн баясах ХХК	600	22.800.000
	<b>ДҮН</b>					<b>421.900.000</b>